

Монголын орчин үеийн хүүхдийн туужийн үүсэл, хөгжил

Э. Амарзаяа*

Хураангуй

Монголын хүүхдийн тууж нь хүүхдийн амьдрал, зан төлөв, сэтгэлзүйн онцлогийг уран сайхнаар илэрхийлэн гаргадаг хүүрнэл зохиолын чухал төрөл зүйл юм. Монголын хүүхдийн уран зохиолын салбарт 1930-аад оноос эхлэн “Хоньчин Найдан” (1935), “Болд Самбуу хоёр” (1936), “Сурагч Ганбат” (1940) зэрэг зохиол хэвлэгдсэн нь “хүүхдийн тууж” үүсэх үндэс болжээ. 1950 оноос баримтат, адал явдалт, танин мэдэхүй, үлгэр, хошин, уран зөгнөлт сэдвээр “Манай сургуулийнхан” (1952), “Залуу жуулчид” (1952), “Алим” (1952) тэргүүтэй олон тооны тууж хэвлэгдэн гарсан нь хүүхдийн тууж бие даасан том төрөл зүйл болон хөгжихөд чухал нөлөө үзүүлжээ.

Эдүгээ бүртгэн тоолж үзэхэд 1930-аад оноос хойших хугацаанд 150 гаруй зохиолчийн 500 орчим хүүхдийн тууж зохиогдон хэвлэгдсэн нь баттай мэдэгдээд байна. Эдгээр туужийг Адал явдал, Баримтат, Танин мэдэхүйн, Уран зөгнөлт, Үлгэр тууж, Хошин хөгжөөнтэй, Хүүрнэл тууж, Шүлэглэсэн тууж хэмээн 8 үндсэн хэлбэрт ангилах боломжтой. Судалж үзвэл хүүхдийн багавтар тууж 3000-5000 үгтэй, дунд хэмжээний тууж 5000-10000 үгтэй, томоохон тууж 10000-20000 үгийн хооронд бичигдэж байна. Мөн уншигчдын насны онцлогоор нь бага ангийнханд зориулсан, дунд ангийнханд зориулсан, ахлах ангийнханд зориулсан хэмээн гурван хүрээнд хуваах нь тохиромжтой ажээ. Хүүхдийн тууж ингэж дэлгэрэн хөгжихдөө хүүхдийн дотоод ертөнц, амьдралын хэв маяг, томчуудаас хүүхдэд ирж буй тусгал, нийгэм хүүхэд хоёрын харилцааг гүнзгий илэрхийлэн гаргадаг сонирхолтой төрөл болжээ.

Түлхүүр үг

Хүүхдийн уран зохиол, хүүхдийн уран зохиолын төрөл зүйл, хүүхдийн тууж судлал

Удиртгал

Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиол ХХ зууны эхэн үеэс эхлэлтэй. Эдүгээ хүүхдийн уран зохиолын салбар хүүхдийн шүлэг, хүүхдийн өгүүллэг, хүүхдийн тууж, хүүхдийн найраглал, хүүхдийн жүжиг гэх зэрэг төрөл зүйлийн хувьд өргөжин дэлгэрч арвин баялаг сан хөмрөгтэй болжээ. Хүүхдийн тууж нь хүүхдийн зан төлөв, амьдралын хэв маяг, сэтгэл зүйн дотоод мөн чанарыг гүн гүнзгий илэрхийлэн гаргадаг уран сайхны өвөрмөц шинжтэй бөгөөд өсвөр насны хүүхдэд тохиолдож байдаг үйл явдлууд, хүүхэд болон насанд хүрэгчид хоорондын зөрчил, хорвоо ертөнцийн тухай ойлголт зэргийг тод томруун, илэрхий бодитой, яруу сайхнаар харуулж чадах чухал төрөл болжээ. Хүүхдийн туужийн үүсэл, хөгжлийг судлах нь хүүхдийн уран зохиол судлал, төрөл зүйлийн онолын ойлголтыг тодруулах, гүнзгийрүүлэх чухал ач холбогдолтой.

Хүүхдийн туужийн үүсэл, хөгжил

“Хүүхдийн тууж” хэмээх нэршил монголын хүүхдийн уран зохиолд 1960-аад оноос хэрэглэгдэж эхэлжээ. Харин “тууж” хэмээх нэршил монгол хэлний үгийн санд өнө эртний

улбаатай. Эртний монголын уран зохиолд “тууж” хэмээх нэрлэгдсэн зохиол элбэг бий. Тухайлбал, “Хоёр загалын тууж”, “Убаши хунтайжийн тууж”, “Хув Нагваралын тууж”, “Чойжид дагины тууж”, “Тэсэрийн тууж”, “Хар үхэрт хүүгийн тууж” зэрэг “тууж” хэмээн онцлон нэрлэгдсэн олон зохиол байдаг. Гэхдээ эдгээрийг орчин үеийн туужтай шууд холбон ойлгож болохгүй. “Тууж” хэмээх нэршил одоогийнх шиг цэгцэрсэн нэг бүхэл утгаар биш олон утгаар хэрэглэгдэж байжээ.

“Туужийн дотор их төлөв хүний амьдралын нэг үеийн явдлыг дүрслэн үзүүлдэг байна. Хүн аж амьдралдаа бага нас, идэр залуу үе, сургуулийн үе, цэргийн алба буюу албан ажил хийсэн үе, өтөлж хөгшрөх үе зэрэг хэд хэдэн үеийг өнгөрөөдөг байна. Үүний аль нэгийг буюу эсвэл хоёр гурвын зэрэг үеийн байдлыг дүрслэн үзүүлдэг зохиолыг тууж гэдэг байна.” (Гаадамба, 1989, х.196)

Хүүхдийн туужид хүүхдийн амьдралын тухай буюу хүүхдийг тойрон хүрээлсэн үйл явдлын тухай өгүүлдэг. Тийм болохоор хүүхдийн туужийн баатрууд ихэвчлэн хүүхэд байдаг. Монголын уран зохиол дахь “хүүхдийн тууж” хэмээх ойлголтыг орос хэлний “детская повесть”-той дүйцүүлэн ойлгож болно. Хүүхдийн тууж оросын хүүхдийн уран зохиолд хэдийн байр сууриа олсон төрөл

* ✉ zohiolch_amarzaya@yahoo.com

юм. Өрнөдийн утга зохиолд хүүхдийн тууж нь “children’s novella” хэмээх нэршилтэй дүйж байдаг. Оросын утга зохиолд хүүхдийн туужийг өгүүллэг буюу романаас ялгах гол хэмжүүр нь утга агуулга, хэлбэр хэмжээ гэж үздэг бол өрнөдийн утга зохиол судлалд уг зохиолыг бүрдүүлж байгаа үгийн тоогоор хэмжиж төрөл зүйлийг тодорхойлдог байна. Тухайлбал, “Барууны хэвлэлийн газрууд тухайн бичвэрийн урт богинын хэмжээгээр төрөл зүйл тогтоох үзүүлэлт гаргадаг байна. Роман (novel) гэхэд 40 мянгаас дээш үгтэй, 17500-40000 үгтэй бол novella” 75000 үгтэй бол novelette гэж тооцдог”. (Аюурзана, Өлзийтөгс, 2007, х.9)

Монголын уран зохиолд хүүхдийн анхны тууж хэзээ зохиогдсон бэ? гэдэг сонирхолтой асуулт бий. 1921-1935 оны хоорондох зохиолуудаас хүүхдийн туужийг нягтлан шүүрдэж үзвэл С. Буяннэмэхийн “Алсыг зорьсон алтан загас” тууж анхаарал татаж байна. 1927 онд зохиолч С.Буяннэмэх буриадын эрдмийн хүрээлэнгийн захиалгаар “Багачуудын баясгалант бичиг” нэртэй хүүхдийн өгүүллэгийн цоморлиг бичсэн авч монголд хэвлүүлж чадаагүй байна. Эрдэмтэн С.Лувсанвандан 1965 онд Улаан-Үд хотноо эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бичмэлийн санд ажиллаж байхдаа энд 40-өөд жилийн туршид нандигнан хадгалагдсан энэхүү цоморлигийг олж 1967 онд “Бор, бор болжмор” нэртэйгээр хэвлүүлсэн байна. “(Оюунбадрах, 2010, х.28) Эл номд “Алсыг зорьсон алтан загас тууж” орж анх удаа хэвлэгджээ. Тус зохиолыг шинжлэн судалбал ихэд сонирхолтой өгүүлэмжтэй ба ерөнхий агуулга, үйл явдал, өрнөл, дүр баатрууд зэрэг нь “Алсыг зорьсон алтан загас”-ыг хүүхдийн үлгэр тууж мөн болохыг нь бүрэн илтгэдэг.

Хүний ертөнцийн элдэв явдлыг амьтны ертөнцөд хувиргах, хүнийг амьтнаар төлөөлүүлэх, дүр болгосон амьтад хүний хэлээр чөлөөтэй ярилцах, танин мэдэхүйн аялал хийх зэрэг нь монголын хүүхдийн уран зохиолд өргөн хэрэглэдэг, уран дүрслэлийн арга барил юм. Зохиолын хэв маяг, агуулга, өгүүлэмж нь хүүхдийн уран зохиолын үндсэн арга барил, үзэл баримтлалтай нийцэх учраас “Алсыг зорьсон алтан загас” зохиолыг хүүхдийн тууж гэж үзэж болно. Өвөрмөц содон бичлэг, үлгэрчилсэн өгүүлэмж нь бусад реалист зохиолуудтай харьцуулахад ихэд сонин учраас судлаачид олон янзаар тайлан тайлбарлахад хүргэжээ.

1930 оноос хүүхдийн өгүүллэгээс, хүүхдийн тууж руу шилжсэн зохиол бичих ажлыг зохиолч Д. Цэвэгмид хийв. Түүний бичсэн “Хоньчин Найдан” (1935), “Бургаст голын Болд, Самбуу хоёр” (1936), “Сурагч Ганбат” (1940) зэрэг зохиол нь хүүхдийн цуврал туужийн шинжтэй. Дээрх гурван зохиолыг дэлгэрүүлэн үзье. Д. Цэвэгмид “Хоньчин Найдан”

зохиол хамгийн анх 1935 оны 10 сард “Үндэсний соёлын зам” сэтгүүлд хэвлэгджээ.

Уг туужид нэгэн ядуу малчин айлын балчир хүү Найдан аав, ээжийн хамт харамч хахир захирагч Сүрэнгийн малыг хариулж амь зуудаг байлаа. Нэгэн удаа Найдан хонио алсын бэлчээрээс гэрийн зүг эргүүлж туусаар явтал оройтож улмаар шөнийн харанхуй болов. Хүү харанхуй шөнө ганцаар явахдаа ихэд айж, араатан чоно шөнө анд гардаг гэдгийг санахаас жихүүцэн хонио шамдан тууж явав. Тэгтэл хонин сүрэг нэг юмнаас үргэн хуйларч зэвүүн муухай дуу сонсогдож улмаар нэг ямааг нь чоно идчихжээ. Найдан үргэсэн хонио арайхийн тогтоож байтал шөнийн харанхуйд захирагч Сүрэн давхин ирсэн ба “шөнө болтол хонь хээр байлгав”, “санаатайгаар чононд ямаа идүүлэв” хэмээн ихэд загнаж, толгойг нь булуу болтол уургаар зоджээ. Энэ мэтчилэн харгис захирагчийн дарлал, доромжлол дор Найдан хүү эцэг эхээсээ төөрөлдөж, их зовлон туулна. Олон жилийн дараа ардын хувьсгал ялан мандсан ба Найдан хүү ч эрийн цээнд хүрч, өөрийн гэсэн гэр бүл үр хүүхэдтэй болно. Бага балчир цагт төөрөлдөж алга болсон эцгийнхээ сургийг дуулж баярын оч гийнэ. Хэдий бага насандаа өнчирч, зовж зүдэрсэн боловч шинэ цагийн ивээлээр сайхан амьдралтай золгож байгаа нь энэ зохиолын ерөнхий санаа юм.

Д.Цэвэгмидийн дараагийн тууж болох “Бургаст голын Болд Самбуу” зохиол 1936 онд “Үндэсний соёлын зам”-д нийтлэгджээ. Хожим ном зохиол, сурах бичигт хэвлэгдэхдээ “Бургаст голын” гэдэг үг нь хасагдаж “Болд, Самбуу хоёр” хэмээн нэрлэгдэх болжээ. Уг туужид нэгэн хийдэд шавилан суудаг Самбуу хэмээх хүүгийн амьдралыг харуулжээ. Самбуу хүү өөрийн найз Болд охины тусламжтайгаар хийдийн бурангуй амьдралаас холдож хотын сургуульд орж хөгжил дэвшилд суралцан, гэрэлт ирээдүйтэйгээ золгож байгаа тухай гардаг. 1930-аад оны үеийн ном зохиолд хүүхдийн баясгалант амьдрал, хөгжөөнтэй байдлыг үзүүлэх нь ховор, өнгөрсөн нийгмийн бурангуйг дэлгэн харуулах хандлага зонхилж байв.

Ардын хувьсгалын ачаар монгол орны хүүхэд багачууд хуучин нийгмийг орхиж, шинэ цаг үед аз жаргалтай, эрх тэгш амьдарч сургуульд сурч их мэдлэгийн замд орж байгаа тухай “Сурагч Ганбат” хэмээх гурав дахь тууж 1941 онд “Зохиолын цоморлиг” сэтгүүлд хэвлэгдсэн бөгөөд агуулга хэлбэрийн хувьд “Хоньчин Найдан” туужийн үргэлжлэл юм. Хоньчин Найдан, сурагч Ганбат нарын эцэг адилхан “Зориг” гэсэн нэртэй байдаг. Өмнөх туужуудаа бодвол “Сурагч Ганбат” нь зохиомж урлалын хувьд тааруухан, амьдралаас

хөндий хуурай бичлэгтэй, хүүхдийн дотоод ертөнцөөс холдсон, үзэл суртлыг түлхүү шингээсэн зохиол болсон. Уран сайхны хувьд тааруухан болсон ч гэлээ социалист нийгмийн шаардлага үзэл хандлага, хөгжил дэвшлийн төлөөх зорилгод ихэд нийцэж байсан бүтээл юм.

Үүний дараа Ч.Лодойдамба “Манай сургуулийнхан” тууж 1952 онд хэвлэгдэн гарчээ. Энэ туужгарсан даруйдаа хэлбэр хийц, уран сайхны шинэлэг байдлаараа уншигчдын анхаарлыг ихээр татаж, утга зохиол судлаачдын дунд өндөр үнэлгээ авсан. Уг туужтай харьцуулахад С.Буяннэмэх “Алсыг зорьсон алтан загас” (1927), Д.Цэвэгмид “Хоньчин Найдан” (1935), “Болд Самбуу хоёр” (1936), “Сурагч Ганбат” (1940 зэрэг тууж нь дүрийн тоо, үйл явдал, хэлбэр хэмжээний хувьд хураангуй бөгөөд, товчилсон өгүүлэмжтэй байдаг. Харин “Манай сургуулийнхан” хэлбэр хэмжээ, дүр баатрууд, үйл явдал ихтэй томоохон тууж болжээ. Ийм болохоор “Энэ тууж уншигчдын сонирхлыг ихээр татсан, тухайн үеийн туужийн төрөлд гарсан шинэ үзэгдэл болсон юм” (Лувсанвандан, Мөнх, Сампилдэндэв, 1989, х.394).

Ийнхүү 1927-1952 оны хооронд хүүхдийн таван тууж зохиогджээ. Хэдийгээр тооны хувьд цөөхөн ч гэсэн эдгээр зохиол нь хүүхдийн туужийн хөгжилд чухал алхам болсон. Үүний дараа 1952 оноос хойш Н. Надмид “Залуу жуулчид” (1952), Д. Намдаг “Алим” (1952), П. Хорлоо “Говийн хүү” (1956), Д. Мягмар “Балын амт” (1965), Л. Түдэв “Нөхөд” (1956), “Осолтой жим” (1957), “Төөрөгсөд” (1963), “Будаг амилна” (1967), “Мөнхийн ус” (1969), “Хорвоотой танилцсан түүх” (1970), Ч. Арьяасүрэн “Сүүлэнхүү” (1965) Д. Гармаа “Гавьяат үйлсийн мөрөөдөл” (1967), “Нэгэн зуны намтар” (1968), Ч. Алагсай “Ирвэст уул” (1970), Р. Ядмаа “Галд нэмэрлэсэн цучил” 1965, “Бараан хясаатын нууц” (1971), Ч. Лувсанжав “Дамдины бага хүү” (1968), “Д. Сүхбаатар” (1970), М. Чимид “Шар цамцат” (1965), Магаллен хаагуур гарсан бэ? (1975), Ш. Гаадамба “Багын явдал” (1975), С. Надмид “Сүүдэрхүү” (1972), “Дааганы уралдаан” (1975) тэргүүтэй олон хүүхдийн тууж хэвлэгджээ.

Энэ талаар, “Жар далаад онд хүүхдэд зориулсан тууж их хөгжлөө. Энэ бол манай үеийн тууж бичлэгт, ер нь монгол хүүхдийн утга зохиолын том амжилт юм. Бяцхан иргэдэд зориулж “том” зохиол бичиж өгөх буянтай үйлсийг зохиолч Л.Түдэв, П.Хорлоо, М.Чимид, Д.Гармаа, С.Адмид нар хошуучилж байна” хэмээн тодорхойлсон байна (Цэнд-Аюуш, 1981, х.32). 1960-аад оноос “хүүхдийн тууж” хэмээх оноосон нэршил бий болов.

1921-1980 оны хооронд 510 тууж хэвлэгдсэн

хэмээн эрдэмтэн Д.Цэнд-Аюуш “Монгол тууж” (1981) номдоо нэрсийн жагсаалт хийжээ. “Монголын орчин үеийн уран зохиолын түүх IV” (2014) номын 174 талд “1924 оноос хойш 1000 шахам тууж нийтлэгдсэн” гэжээ. Эдгээр тооцоонд хүүхдийн туужууд бүрэн ороогүй. Эдүгээ нэрсийн жагсаалт хийн тоолж үзэхэд 150 гаруй зохиолчийн 500 орчим хүүхдийн тууж зохиогдон хэвлэгдсэн нь баттай мэдэгдээд байна. Эдгээр туужийг сэдэв, агуулга, хэлбэр хэмжээ, уран сайхны онцлог зэргийг нь харгалзан,

1. Адал явдал
2. Баримтат (түүхэн, дурсамжит, баримтат, намтарчилсан зохиол)
3. Танин мэдэхүйн (ан амьтан, байгаль орчин)
4. Уран зөгнөлт,
5. Үлгэр тууж, уран сэтгэмжит
6. Хошин хөгжөөнтэй
7. Хүүрнэл тууж
8. Шүлэглэсэн тууж

хэмээн ангилж болохоор байна.

Намтарчилсан түүхэн сэдэв гэдэгт түүхэн туужууд, намтраар бүтээсэн зохиол, баримтат туужуудыг багтана. Мөн уламжлалт ардын аман зохиолоос орчин үеийн хүүхдийн туужид уламжилсан сэдэв өгүүлэмж нэн элбэг. Орчин үеийн хүүхдийн үлгэр-тууж, уран сэтгэмжийн тууж, намтарчилсан тууж зэрэгт аман зохиолын тодорхой нөлөө (үлгэр домог, эртний зохиолууд, үлгэрийн өгүүлэмж, зүйр цэцэн үг, аман яриа, хүүхдийн тоглоом наадгай) орсон байдаг.

Төрөл зүйлийг тодорхойлох өрнөдийн хэвлэлийн газрын аргачлалаар зарим хүүхдийн туужийн үгийн тоог тооцож үзвэл, С. Надмид “Дурлачихжээ”-3895, Д. Цэвэгмид “Хоньчин Найдан”-4187, Н. Мандал “Бондхой” -4914, Ц. Мөнх “Банхар минь”-5724, Д. Гармаа “Аав цэцэрлэгт орсон нь”-7090, Ш. Цэнд-Аюуш “Адтай Мятав” -7016, Д. Мягмар “Балын амт”-9484, С. Надмид “Сүүдэрхүү”-14023, Л. Түдэв “Хорвоотой танилцсан түүх”-19302, Ш. Гаадамба “Багын явдал” -24321 зэрэг үгтэй байна. Эдгээрээс харвал хүүхдийн багавтар тууж 3000-5000 үгтэй, дунд хэмжээний тууж 5000-10000 үгтэй, томоохон тууж 10000-20 000 үгтэй гэж үзэж болохоор байна. Гэхдээ бичвэрийн хэмжээгээр хүүхдийн туужийг тодорхойлох нь учир дутагдалтай. “Хүүхдийн туужийн их багын хэмжээ гол шаардлага биш, сэдэв, агуулга, уран дүрслэлээрээ хүүхдийн сонирхлыг татаж тэдний хүмүүжилд нөлөөлөн мэдлэгийн хүрээг өргөтгөсөн байх нь чухал” (Арьяасүрэн, 1980, х.71) Уншигчийн насны онцлог байдалтай уялдаж хүүхдийн туужийн их багын хэмжээг тодорхойлж болно. Сургуулийн бага ангийн хүүхдэд хэтэрхий урт тууж уншуулах,

эсвэл ахлах ангийн сурагчид хэт богинохон тууж зохиож өгөх нь тохиромжгүй. Тухайлбал, “Багын явдал” тууж бол үнэхээр хүүхдэд таарсан, богино бүлэг хэсгүүдтэй, хурц үйл явдалтай, донжийг нь олсон шог хошин аястай, бүлэг бүр хоорондоо уялдаа холбоотой, амьдралд байдаг үнэн зүйлийг уншигчдын өмнө дэлгэснээр онцын сонирхолтой зохиол болж чадсан байдаг.” (Байгалсайхан, 2014, х.113)

Хүүхдийн тууж ингэж дэлгэрэн хөгжихдөө хүүхдийн дотоод ертөнц, амьдралын хэв маяг, томчуудаас хүүхдэд ирж буй тусгал, нийгэм хүүхэд хоёрын харилцааг гүнзгий илэрхийлэн гаргадаг сонирхолтой төрөл болжээ. Хүүхдэд тохиолдож байдаг өдөр тутмын үйл явдлууд, хүүхэд болон насанд хүрэгчид хоорондын зөрчил, бие хүний ойлголт зэргийг тод томруун, илэрхий бодитой, яруу сайхнаар харуулах явдал нь хүүхдийн туужийн үндсэн онцлог. Эдүгээ хүүхдийн тууж сэдэв, агуулга хэлбэрийн хувьд өргөжиж, хүүхдийн уран зохиолын бие даасан чухал төрөл болжээ.

Дүгнэлт

1. XX зууны эхэн үеэс С. Буяннэмэх “Алсыг зорьсон алтан загас” (1927), Д. Цэвэгмид “Хоньчин Найдан” (1935), “Бургаст голын Болд, Самбуу хоёр” (1936), “Сурагч Ганбат” (1940), Ч. Лодойдамба “Манай сургуулийнхан” (1952) зэрэг анхны тууж хэвлэгдсэн. Эдгээрт хуучин нийгмээс шинэ нийгэмд дэвших үеийн хүүхдийн амьдралыг дүрсэлж, хоцрогдсон бүдүүлэг цагийн

хөөрхийлөлтэй хүүхдийн дүрийг шинэ цагийн хөгжингүй, сурч боловсрох хүсэл тэмүүлэлтэй хүүхэд болгон харуулснаараа хүүхдийн туужийн хөгжилд дүрийн өсөлт харуулах чухал туршлага болсон.

2. 1952 оноос хойш хүүхдийн тууж бичих ажил эрчээ авч Н. Надмид “Залуу жуулчид” (1952), Д. Намдаг “Алим” (1952), П. Хорлоо “Товийн хүү” (1956), Л. Түдэв “Нөхөд” (1956) тэргүүтэй 500 орчим тууж бүтээгдсэн явдал нь төрөл зүйлийн хувьд өргөн дэлгэр, хүүрнэл, уран зөгнөлт, түүхэн, баримтат, үлгэрчилсэн, шүлэглэсэн зэрэг сэдэв, агуулга, хэлбэрийн олон талт арга барилыг хөгжүүлсэн, монголын хүүхдийн уран зохиол дотроо томоохон төрөл зүйл болсныг харуулдаг.

Ашигласан материал

- Арьяасүрэн, Ч. (1980). Орчин үеийн монголын хүүхдийн утга зохиол. Улаанбаатар
- Аюурзана, Г. Өлзийтөгс Л. (2007). Монголын сонгомол өгүүллэг. Улаанбаатар
- Байгалсайхан, С. (2014). XX зуун тууж судлал. Улаанбаатар
- Гаадамба, Ш. (1989). Утга зохиолын онолын үндэс. Улаанбаатар
- Оюунбадрах, Д. (2010). Монголын хүүхдийн уран зохиол III дэвтэр. Улаанбаатар
- Цэнд-Аюуш, Ш. (1981). Монгол тууж. Улаанбаатар
- Лувсанвандан, Мөнх, Сампилдэндэв, нар. (1989). Монголын орчин үеийн уран зохиолын түүх II боть. Улаанбаатар

Development of Modern Children's novella

E.Amarzaya

Abstract

Mongolian Children's novella is one of main type of Mongolian fiction that expresses children's life, behavior, psychological characters. Following stories published since 1930: “Sheepman Naidan” (1935), “Bold and Sambuu” (1936), “Pupil Ganbat” (1940) etc, thus become fundamental of Children's novella. Since 1950 there are many documentary, adventure, science, tale, comedy, fantasy stories published such as “My schoolmates”(1952), “Young torists” (1952), “An apple”(1952). So that influenced Children's novella to develop and become one of main fiction type.

It is known that approximately 500 children's novella of 150 authors published since 1930. It is possible to sort into 8 type: adventure, documentary, science, tale, comedy, fantasy, narration and poetry stories. If we review, Children's little novella is with 3000-5000 words, average is with 5000-10000, larger one is mostly with 10000-20000 worlds. So that it is practicable divide Children's novella into 3 types such as for elementary, grammar and graduate school. While growing up, Children's novella become a clear indicator of children's interior, life style, mirror of adults, communication between kids and sociality.

Key words

Children's novella, types of Children's novella, children's fiction study